

**2023 ОНЫ 08 ДУГААР САРЫН 29-НИЙ ӨДРИЙН НИЙСЛЭЛИЙН УДИРДАХ
АЖИЛТНУУДЫН ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР**

2023 оны 08 дугаар сарын 29

Улаанбаатар хот

№	Товч агуулга	Хэрэгжилт ирүүлэх байгууллагууд
1	Нийслэлийн Засаг даргын 2023 оны Нийслэлийн “2023-2024 оны өвөлжилтийн бэлтгэл хангах тухай” А/817 дугаар захирамжийн хэрэгжилтийг сайтар хангаж, хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлуудыг бүх шатандаа эрчимжүүлж ажиллах.	-Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс -Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын хэлтэс
2	Өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд байгууллагуудын тусгай зориулалтын авто машин, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг шалгах, мөн тусгай зориулалтын авто машинаар парк шинэчлэх ажлуудаа эрчимжүүлж ажиллах. /Захирагчийн ажлын алба, Дүүргийн Засаг дарга нар, Хэрэгжүүлэгч агентлагууд, Инженер хангамжийн байгууллагууд /	-Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс
3	Улаанбаатар хотын дулаан хангамжийн ашиглалтын хэвийн, найдвартай үйл ажиллагааг хангах, бүтээн байгуулалт, шугам сүлжээний их, урсгал засварын хугацаанд дуусгах ажлаа эрчимжүүлж, нөхөн сэргэлтийг чанартай гүйцэтгэх. /Захирагчийн ажлын алба, Дүүргийн Засаг дарга нар, Хэрэгжүүлэгч агентлагууд, Инженер хангамжийн байгууллагууд, Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар/	-Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс
4	Нийслэлийн Засаг даргын 2023 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/728 дугаар захирамжийн хэрэгжилтийг сайтар хангаж, ажлаа эрчимжүүлж ажиллах. /Дүүргийн Засаг даргын нар/	-Хяналт, шинжилгээ үнэлгээний хэлтэс
5	Ил задгай худалдан борлуулж байгаа хоол, хүнсний, бараа бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуйн шаардлага, аюулгүй байдлыг хангуулах хяналт шалгалтыг эрчимжүүлж ажиллах. /Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс Нийслэлийн Боловсролын газар, Эрүүл мэндийн газар,	-Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс

№	Товч агуулга	Хэрэгжилт ирүүлэх байгууллагууд
	Хүнс, хөдөө аж ахуйн газар, Мал эмнэлгийн газар, Дүүргийн Засаг дарга нар/	
6	Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх болон тэдгээрийг хадгалах, тээвэрлэх, худалдах, үйлчлэх, импортлох, экспортлох, хүнсийг савлах, шошготой зэрэг хүнсний сүлжээний бүх үе шатны хяналт шалгалтыг эрчимжүүлж ажиллах. /Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс Нийслэлийн Боловсролын газар Эрүүл мэндийн газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар Мал эмнэлгийн газар, Дүүргийн Засаг дарга нар/	-Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс
7	Нийслэлийн хэмжээнд гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлаа эрчимжүүлж, олон нийтэд тогтмол мэдээлж ажиллах. /Нийслэлийн Цагдаагийн удирдах газар Дүүргийн Засаг дарга нар/	-Дүүрэг дэх Цагдаагийн газар
8	Дүүргүүд өөрсдийн нөөц, төсвийн зохицуулалтын хүрээнд үерийн улмаас эвдэрч гэмтсэн зам, гудамж, талбай, ногоон байгууламжуудаа нөхөн сэргээх ажлуудаа эрчимжүүлэх. /Дүүргийн Засаг дарга нар/	-Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс -Онцгой байдлын хэлтэс

2023 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн 12:00 цагт цаасаар гарын үсэг,тамга тэмдэг дарж баталгаажуулан сканердан Т.Түвшинжаргал /ер/ хаягаар,мөн файлаар ирүүлнэ үү.

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

2023 ОНЫ 08 ДУГААР САРЫН 29-НИЙ ӨДРИЙН НИЙСЛЭЛИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН ЭЭЛЖИТ
ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧААС
ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ

2023 оны 08 дугаар сарын 29

Улаанбаатар хот

№	Үүрэг, даалгаврын дагуу хийж, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	Үүрэг, даалгавар биелүүлээгүй шалтгаан	Цаашид авч хэрэгжүүлэх арга зам	Оноо
Үүрэг даалгавар НЭГ: Нийслэлийн Засаг даргын 2023 оны Нийслэлийн “2023-2024 оны өвөлжилтийн бэлтгэл хангах тухай” А/817 дугаар захирамжийн хэрэгжилтийг сайтар хангаж, хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлуудыг бүх шатандаа эрчимжүүлж ажиллах.				
1	<p>Дүүрэгт Улс, нийслэл, нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны төсвийн хөрөнгө оруулалтын нийт 59 төсөл арга хэмжээ хэрэгжиж байна. Үүнээс :</p> <ul style="list-style-type: none">• Бэлтгэл ажил хийгдэж байгаа 4 төсөл арга хэмжээ:• Тендерийн шатандаа байгаа 7 төсөл арга хэмжээ:• Гэрээ байгуулах шатандаа байгаа 0 арга хэмжээ:• Гэрээ байгуулагдан ажил хийгдэж байгаа 23 төсөл арга хэмжээ: <p>Ажил 100 хувь дууссан 24 төсөл арга хэмжээ тус тус байна.</p> <p>Дүүргийн нутаг дэвсгэрт хийгдэж байгаа авто зам, барилга байгууламжийн ажилд хяналт тавих ажлын хүрээнд нийт 26 гүйцэтгэгч компанид “Хөрөнгө оруулалтын ажлыг эрчимжүүлэх тухай” 2023 оны 06 дугаар сарын 30-ний өдрийн 7/1698 тоот албан бичгийг хүргүүлэн, хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний явцын дэлгэрэнгүй тайланг авч ажилласан.</p> <p>Дүүргийн Засаг дарга 2023 оны 08 дугаар сарын 30-ний өдөр Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа барилга байгууламжийн ажлын явцыг шалгаж газар дээр нь ажилласан.</p>			70
Үүрэг даалгавар ХОЁР: Өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд байгууллагуудын тусгай зориулалтын авто машин, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг шалгах, мөн тусгай зориулалтын авто машинаар парк шинэчлэх ажлуудаа эрчимжүүлж				

ажиллах. /Захирагчийн ажлын алба, Дүүргийн Засаг дарга нар, Хэрэгжүүлэгч агентлагууд, Инженер хангамжийн байгууллагууд /				
2	2023-2024 оны өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд дүүргийн Тохижилт үйлчилгээ ХХК Хог тээврийн тусгай зориулалтын 4 авто машин парк шинэчлэлт хийсэн. Үүнээс:Задгай тэвштэй-3, үүрдэг авто машин-1 нийлүүлээд байна. Мөн зуслан ногоон бүсийн хог тээвэрлэлт хариуцсан Наашаа трейд ХХК 2023-2024 оны өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд хог хаягдлын тусгай зориулалтын задгай тэвштэй 14,5 тонн бүхий нэг авто машин, тусгай зориулалтын битүү шахдаг 3,5 тонн бүхий нэг авто машиныг тус тус нийлүүлсэн.			90
Үүрэг даалгавар ГУРАВ: Улаанбаатар хотын дулаан хангамжийн ашиглалтын хэвийн, найдвартай үйл ажиллагааг хангах, бүтээн байгуулалт, шугам сүлжээний их, урсгал засварын хугацаанд дуусгах ажлаа эрчимжүүлж, нөхөн сэргэлтийг чанартай гүйцэтгэх. /Захирагчийн ажлын алба, Дүүргийн Засаг дарга нар, Хэрэгжүүлэгч агентлагууд, Инженер хангамжийн байгууллагууд, Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар/				
3	Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/817 дугаар захирамжийн хэрэгжилтийг ханган дүүргийн Засаг даргын 2023 оны А/236 дугаар захирамжаар 45 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулагдаж 2023 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн Засаг даргын зөвлөлийн хурал, 2023 оны 08 дугаар сарын 28-ний өдөр ажлын хэсгийн хурлаар өвөлжилтийн бэлтгэх хангах ажлын явц болон тулгамдаж байгаа асуудлаар мэдээлэл авч ажлыг эрчимжүүлэх, сар бүрийн 20-ний өдрийн дотор нарийвчилсан тайлан, мэдээг ирүүлэх бөгөөд дүүргийн Засаг даргын зөвлөлийн ээлжит хуралдаанаар тайланг танилцуулж ажиллах талаар үүрэг чиглэл өгч ажилласан.			30
Үүрэг даалгавар ДӨРӨВ: Нийслэлийн Засаг даргын 2023 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/728 дугаар захирамжийн хэрэгжилтийг сайтар хангаж, ажлаа эрчимжүүлж ажиллах. /Дүүргийн Засаг даргын нар/				
4	Төрийн хяналт шалгалтын тухай хуульд заасны дагуу дүүргийн нутаг дэвсгэрт хяналт шалгалтыг хэрэгжүүлэх улсын байцаагчдын үйл ажиллагааг нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллах ажлын хэсэг 2023 оны 08 дугаар сарын 31-ний өдөр хуралдлаа. Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон ажлын хэсгээс ирүүлсэн 17 үүрэг, чиглэлийн дагуу төлөвлөгөө боловсруулан хяналт шалгалтын ажлаа эрчимжүүлэн ажиллаж байна.			70

Үүрэг даалгавар ТАВ: Ил задгай худалдан борлуулж байгаа хоол, хүнсний, бараа бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуйн шаардлага, аюулгүй байдлыг хангуулах хяналт шалгалтыг эрчимжүүлж ажиллах. /Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс Нийслэлийн Боловсролын газар, Эрүүл мэндийн газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Мал эмнэлгийн газар, Дүүргийн Засаг дарга нар/				
5	Дүүргийн Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн “Дүүргийн нутаг дэвсгэрт улирлын чанартай түр сүүдрэвчтэй худалдаа, үйлчилгээ болон түргэн хоолны цэгийн байршил батлах тухай” А/182 дугаар захирамжаар зайрмагийн киоск 18, түргэн хоол 7, тоглоомын үйлчилгээ 13, худалдаа 14 нийт 52 цэгийн байршил батлагдсан. Батлагдсан байршилд ил задгай худалдаа, үйлчилгээ эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгжүүдэд дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс худалдан борлуулж байгаа хоол, хүнсний, бараа бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуйн шаардлага, аюулгүй байдлыг хангуулахад өдөр тутам тогтмол хяналт тавин ажиллаж байна. Нийтийн эзэмшлийн гудамж талбайд зорчигчийн хөдөлгөөнд саад учруулж, бараа бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуйн шаардлага хангаагүй зөвшөөрөлгүй үйл ажиллагаа эрхлэгчдэд газар чөлөөлөлтийг хийх талаар мэдэгдэл өгч, үйл ажиллагааг зогсоож ажиллаж байна.			90
Үүрэг даалгавар ЗУРГАА: Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх болон тэдгээрийг хадгалах, тээвэрлэх, худалдах, үйлчлэх, импортлох, экспортлох, хүнсийг савлах, шошготой зэрэг хүнсний сүлжээний бүх үе шатны хяналт шалгалтыг эрчимжүүлж ажиллах. /Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс Нийслэлийн Боловсролын газар Эрүүл мэндийн газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар Мал эмнэлгийн газар, Дүүргийн Засаг дарга нар/				
6	Нийслэлийн Засаг даргын 2023 оны “Хууль, норм, дүрэм, стандартын хэрэгжилтийг хангуулах талаар авах зарим арга хэмжээний тухай” А/242, дүүргийн Засаг даргын 2023 оны А/120 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах хүрээнд дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны 07 дугаар сарын 27-ний өдөр баталсан “Хууль, норм, дүрэм, стандартын хэрэгжилтийг хангуулах талаар авах зарим арга хэмжээний тухай” удирдамжийн дагуу зах, худалдааны төв чиглэлээр 7, хүнсний үйлдвэрлэл чиглэлээр 11 нийт 18 иргэн, аж ахуйн нэгжид холбогдох хууль, тогтоомж, норм, дүрэм, стандартыг хангуулахаар Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс, Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс, дүүргийн Цагдаагийн газар, Онцгой байдлын хэлтэс, Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэс,			90

	<p>Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг хамтарсан хяналт, шалгалтыг 2023 оны 07 дугаар сарын 28-ний өдрөөс 08 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацаанд хийж, үүрэг гүйцэтгэн ажиллаж байна. Хяналт, шалгалтаар эрүүл ахуй хангаагүй, цэвэрлэгээ үйлчилгээ хийгээгүй, хөдөлмөрийн аюулгүй байдал, галын аюулгүй байдал алдагдсан зэрэг нийтлэг зөрчлийг газар дээр нь арилгуулан, стандартыг хангуулахад хугацаатай үүрэг, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Ажлын хэсгийн тайланг 2023 оны 09 дүгээр сарын 10-ний өдөр танилцуулна.</p>			
<p>Үүрэг даалгавар ДОЛОО: Нийслэлийн хэмжээнд гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлаа эрчимжүүлж, олон нийтэд тогтмол мэдээлж ажиллах. /Нийслэлийн Цагдаагийн удирдах газар Дүүргийн Засаг дарга нар/</p>				
7	<p>Дүүргийн 1-24 дүгээр хорооны Засаг дарга нарт Сар бүрийн гэмт хэрэг, зөрчлийн талаарх нөхцөл байдлыг тогтмол танилцуулсан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил арга хэмжээнд Иргэд, Олон нийтийг хамтран ажиллах талаар мэдээ, мэдээлэл тогтмол хүргэж “Ногоон бүс” “Зуслан” арга хэмжээний хүрээнд хийж гүйцэтгэж байгаа ажлын талаар ЦЕГ-ын “Амрыг эрье” нэвтрүүлэг, ТВ-9 телевиз хамтран хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2023 оны 08 дугаар сарын 21-ний өдрөөс 08 дугаар сарын 28-ний өдрүүдэд иргэд олон нийтэд хүргэж ажилласан.</p> <p>Шинэ хичээлийн жилийг угтан зохион байгуулж буй "Хичээл Эхэллээ" нэгдсэн арга хэмжээний хүрээнд 2023 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн 07:00 цагаас 11:00 цаг, 13:00 цагаас 18:00 цагийн хооронд явган эргүүлд 48 чиглэлд 96 алба хаагч, 13 хүүхэд хамгаалагч ахмад настан, ерөнхий боловсролын 28 сургуулийн ойр орчим эцэг эхийн эргүүл, "School police" 223, авто эргүүлийн 9 чиглэлд 18 алба хаагч нийт 350 ажилтан алба хаагч ямар нэгэн зөрчил дутагдалгүй ажиллаж байна.</p> <p>Архи согтууруулах ундаа худалдан борлуулдаг түүгээр үйлчилдэг ААНБ-д 21 насанд хүрээгүй иргэнд үйлчлэхгүй байх талаар нийт 50 ААНБ Зөвлөмж хүргүүлсэн.</p> <p>НИТХ- ийн 2022 оны 05 дугаар сарын 30-ний өдрийн 34 дүгээр тогтоолыг үндэслэн 220 граммын савлагаатай “Газ” шингэрүүлсэн хийг 18 насанд хүрээгүй иргэнд зарж борлуулахгүй байх талаар Зөвлөмж, Зурагт хуудсыг хариуцсан нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа Зах худалдааны төв, 8 нэрийн дэлгүүр, 6 нэрийн дэлгүүр, Түц, Барилгын материал Түргэн үйлчилгээний цэгүүдэд 08 дугаар сарын 30-31-ний өдрүүдэд тараасан.</p>			90

	<p>Хүүхэд-Хөдөлгөөний аюулгүй байдал нэгдсэн арга хэмжээ болон "Хичээл эхэллээ" арга хэмжээний хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрт зохион байгуулсан ажил, Хүүхдийг зам тээврийн осолд өртөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 2023 оны 09 дүгээр сарын 01-ний өдөр SBN телевизэд 3 минутын сэрэмжлүүлэг мэдээ мэдээлэл өгсөн.</p> <p>Хичээлийн шинэ жил эхлэхтэй холбогдуулан Дүүргийн боловсролын хэлтэст энэ оны 08 дугаар сарын 28-ний өдрийн 28л-3/444 зөвлөмжийг хүргүүлсэн. 09 дүгээр сарын 01-ний өдөр Хүүхэд-Хөдөлгөөний аюулгүй байдал, "Хичээл эхэллээ" арга хэмжээний хүрээнд төв зам дагуу байрлах Ерөнхий боловсролын 8 сургуулийн явган гарц болон гадна талбайд Хүүхдийг зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор 8 алба хаагчийн нээлтийн арга хэмжээний үед аюулгүй байдалд хяналт тавин ажилласан.</p> <p>Ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх насны боловсролын байгууллагуудын хичээл эхлэх, тарах цагуудад замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, мөн чиглэлийн тээврийн хэрэгслийн эгнээгээр бусад тээврийн хэрэгсэл явсан, түр болон удаан зогсох журам зөрчсөн үйлдлүүдэд дээр хяналт тавих зорилгоор тусгай дуут дохиогоор тоноглогдсон тээврийн хэрэгслээр voice хэлбэрээр иргэд олон нийтэд түгээн ажиллаж байна. Энэ оны хичээлийн шинэ жил эхэлснээс замын түгжрэл саатал ихсэхээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд Нийслэлийн засаг дарга буюу Улаанбаатар хотын захирагчийн "Тээврийн хэрэгслийг тэгш сондгой дугаараар ялган хөдөлгөөнд оролцуулах" тухай захирамжийн дагуу Дотоодын цэргийн алба хаагч нартай хамтран 2 ээлжээр хяналт тавин ажиллаж байна.</p>			
<p>Үүрэг даалгавар НАИМ: Дүүргүүд өөрсдийн нөөц, төсвийн зохицуулалтын хүрээнд үерийн улмаас эвдэрч гэмтсэн зам, гудамж, талбай, ногоон байгууламжуудаа нөхөн сэргээх ажлуудаа эрчимжүүлэх. /Дүүргийн Засаг дарга нар/</p>				
8	<p>Дүүргийн 19,24 дүгээр хорооны нутаг дэвсгэр дэх голын эрэг дагуу 4 даланг сэргээн, өндөрлөн давхарлаж, гэр нь усанд автсан, гэртээ байх боломжгүй иргэдийг 117-р сургууль дээр байрлуулах ажлыг зохион байгуулан ажилласан.</p> <p>Улаанбаатар хотод 07 дугаар сарын 23-ний өдөр орсон борооны улмаас дүүргийн 5 дугаар хорооны нутаг дэвсгэрт 1 дүгээр байрны подвал, байрны доод талын тавиулынд ус нэвтэрсэн. Уг байрны усыг соруулах, үерээс</p>			70

<p>урьдчилан сэргийлэх хаалт босгох, шуудуу гаргах, элс шуудайлах ажилд 07 дугаар сарын 24-ний өдөр 15 дүйцүүлэх алба хаагч томилогдон үүргээ амжилттай гүйцэтгэсэн.</p> <p>Дүүргийн Засаг даргын захирамжаар 15 дүйцүүлэх алба хаагчид 08 дугаар сарын 15,16,17,18-ний өдрүүдэд томилогдон ажиллаж, 4 айлын хашааг буулган, тээвэрлэж дүүргийн Нийтлэг үйлчилгээний газар ОНӨТҮГ-ийн хашаанд хураасан. Мөн 2 айлыг нүүлгэн шилжүүлж, айлуудын шинээр байршиж буй газар нь гэрийн буурийг засах, хашааг хатгах, гэрийг барьж өгөх ажлуудыг гүйцэтгэсэн. Мөн 08 дугаар сарын 31-ний өдөр “Үерийн дараах сэргээн босголт, үерийн ам дагуу зөвшөөрөлгүй буусан иргэдийг нүүлгэн шилжүүлэх ажил”-ийн хүрээнд нүүлгэн шилжүүлж буй айлуудын шинээр байршиж буй газар нь гэрийн буурийг засах, хашааг хатгах, гэрийг барьж өгөх ажлууд үргэлжлэн явагдаж байна. Дүүргийн Засаг даргын 2023 оны “Гол, усны ослын аюулаас урьдчилан сэргийлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” А/202 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Туул гол, голын тогтоол усанд иргэд осолдохоос урьдчилан сэргийлэх зорилгоор Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын хэлтсийн алба хаагчид 2023 оны 6 дугаар сарын 10-ний өдрөөс 8 дугаар сарын 29-ний өдөр хүртэлх хугацаанд Маршалын гүүрнээс Яармагийн гүүр хүртэл 6,2км зайд гол, усны аюулаас урьдчилан сэргийлэх хөдөлгөөнт эргүүлийн үүргийг 35 удаа гүйцэтгэж нийт 1655 иргэнд сэрэмжлүүлэх заавар зөвлөмж өгч, 1503 ширхэг сэрэмжлүүлэх материал тараан ажилласан.</p> <p>Чингэлтэй дүүргийн 19-24 дүгээр хорооны нутаг дэвсгэрт Гол, усны ослоос урьдчилан сэргийлэх самбар байршуулан ажилласан.</p> <p>Баянзүрх дүүргийн 21 дүгээр хорооны Бага дарь эхийн нэгдүгээр гудамжнаас 127 дугаар сургууль хүртэл үерийн ус урсаж, 246 айл өрх, 12 аж ахуйн нэгж усанд автаж, 105 автомашин, нэг зам үерт урссан. Үүсэн нөхцөл байдалтай холбогдуулан Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын хэлтсийн нийт 35 алба хаагч 2 техник хэрэгсэлтэйгээр ажилласан. Алба хаагчид үерт өртсөн, зам дагуу айлуудыг нүүлгэн шилжүүлэх, самналтын ажлыг хийж, сэргээн босгох ажлыг эхлүүлэн ажилласан. Мөн тойрогт овоорсон, овоолго шороо, үерт автсан машин тэргийг чөлөөлөх ажлыг гүйцэтгэж, хор уршгийг арилгах арга хэмжээг цаг алдалгүй шуурхай зохион байгуулан ажилласан</p>			
--	--	--	--

<p>Баянзүрх дүүргийн 29 дүгээр хорооны үерийн хор уршгийг арилгахаар Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын хэлтсийн 30 алба хаагч, 3 автомашин техник хэрэгсэлтэйгээр ажилласан.</p> <p>Дүүргийн Онцгой байдлын хэлтсээс нийт 33 алба хаагч, дүүргийн сайн дурын бүлэг нэрвэгдэгсдийг эрэн хайх, автозам, гарцыг чөлөөлөх, усанд урссан автомашинуудыг татан гаргах, үерийн усанд автсан иргэдийн гэр, байшин, хашааны усыг соруулах, лаг шаврыг арилгах зэрэг арга хэмжээ авч хэрэгжүүлж, аюулгүй байдлыг хангаж ажилласан.</p> <p>Үер, усны аюулаас урьдчилан сэргийлэх талаар 3 байгууллага нийт 83 ажилтан, алба хаагчдад сургалт зохион байгуулсан.</p> <p>Чингэлтэй дүүргийн 24 дүгээр хороо Зуун мод 3 дугаар хэсэгт үерийн далан, 19 дүгээр хороо Ар согоот 2 дугаар хэсэгт 100м үерийн далан босгосон.</p>			
---	--	--	--

ЗАСАГ ДАРГА

Н.БАТСҮМБЭРЭЛ

ТАНИЛЦСАН: НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

П.БАЯНБААТАР

ТАНИЛЦСАН: ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Л.БАЯРМАА

ХЯНАСАН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
ДАРГА

Н. НАРАНЗУЛ

ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:

ДОТООД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Э.ХУЛАН

НЭГТГЭСЭН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН

Д.БЯМБАСҮРЭН